



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/13

Хэрлэн сум

Үнэлгээний хороо  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5, 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.2, 50.3, 50.4, 50.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжих Хэнтий аймаг дахь политехник коллежийн оюутны дотуур байрны барилгын хэсэгчилсэн засвар, Хэрлэн суманд 4-р сургуулийн дотуур байрны дээвэр болон хэсэгчилсэн засварын ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны

дарга: Б.Дарханбаатар Хууль эрх зүйн хэлтсийн дарга

Нарийн бичиг: Н.Үнэнбат Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн


Гишүүд: Б.Содбилэг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн

Х.Гонгор Иргэний төлөөлөл

Д.Оюун Төрийн бус байгууллагын төлөөлөл

2.Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Б.Дарханбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ